

Аудитын код: САГ-2018/12/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор С.Энхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: enkhtuyas@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	0
2	АУДИТЫН ТАЙЛАН.....	1
2.1	ОРШИЛ	1
2.2	АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	1
2.3	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	2
2.4	АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН....	3
2.5	ДОТООД ХЯНАЛТ	3
2.6	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА.....	4
2.7	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	4
2.8	ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТООЦСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	5
2.9	АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ	5
2.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	5
2.9.2	Авлагын талаар.....	5
2.9.3	Зардлын талаар.....	6
2.10	АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ.....	6
2.11	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД.....	6
2.12	АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	6
2.13	ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	7
2.14	МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР.....	7
2.15	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ.....	7
2.16	АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР	7
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	8
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар	9
3.2	Авлагын талаар.....	10
3.3	Зардлын талаар	11
4	АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	12
4.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Р.СОДХҮҮ ТАНАА

2018.03.23 № 01/806
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



071393

Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 07-наас 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар ОӨУБЕГ-ын харьяа аймаг, нийслэлийн Оюуны өмч, улсын бүртгэлийн 23 байгууллагаас 15 байгууллагын санхүүгийн тайланд аймаг, САГ-2018/12/СТА-ТТ3

01

ЗӨРНИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

нийслэлийн аудитын газрууд аудит хийж, 6 байгууллагын санхүүгийн тайланд “Итгэл” үзүүлж, 2 байгууллагын санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан 15 байгууллагын санхүүгийн тайлан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба уг аудитаар нийт 85.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, үүний 2.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 30.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 52.1 сая төгрөгийн алдааг залруулах, давтан гаргахгүй байх тухай 15 зөвлөмжийг өгсөн байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 3-4/1936 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар нь Монгол Улсын улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлого, эд хөрөнгө, улсын бүртгэлийн үйчилгээг иргэд, хуулийн этгээд, олон нийтэд чанартай шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 2017 онд хуулинд заасан үндсэн чиг үүргийнхээ дагуу иргэний 19, эд хөрөнгийн 26, хуулийн бүртгэлийн 10, зохиогчийн эрхийн 3, аж үйлдвэрийн өмчийн эрхийн 33, архивын 24, нийт 115 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай болгох;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн багц хуулиуд батлагдсантай холбогдуулан дүрэм журмуудыг шинэчлэн боловсруулах;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагааны арга зүйг боловсронгуй болгох;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Төв орон нутгийн оюуны өмч, улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх төлөвлөгөөт сургалт болон шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой сургалтуудыг зохион байгуулж, хүний нөөцийг чадвахижуулах.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын стратегийн зорилтод тусгагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр доорх хууль эрх зүйн акт, журмуудыг шинэчлэн боловсруулсан байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам;
- Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны А/193 тоот тушаалаар батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”;
- Регистрийн дугаарыг олгох, өөрчлөх, хүчингүй болгох журам;

- УБЕГ-ын даргын 2011 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам”;
- УБЕГ-ын даргын 2014 оны 280 дугаар тушаалаар батлагдсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим /ePRS/ системд хөтлөх журам”;
- УБЕГ-ын даргын 2014 оны 1125 дугаар тушаалаар батлагдсан “Загвар, журам батлах”;
- Гадаад хэргийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны А/63, А/15 тушаалаар шинэчлэн батлагдсан “Хилийн чанад дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт иргэний улсын бүртгэл хөтлөх заавар”-ыг тус тус шинэчлэн боловсруулсан байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар тайлант онд 15747 хүүхдэд төрсний гэрчилгээ олгох, 5201 хосын гэрлэлтийн бүртгэх, 45269 иргэнд гадаад паспорт шинээр олгох, 17344 иргэний паспортыг сунгах зэрэг үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны улсын 5492 бүртгэл, газар өмчлөх эрхийн улсын 4936 бүртгэл, гэрээний эрхийн 68441 бүртгэлийг тус тус хийсэн байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.


Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг дунд гэж үзлээ.



2017 онд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудитын алба нь салбарын хэмжээнд 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 2016 оны сонгуулийн зардлын зарцуулалт, зарим аймгийн ОӨУБГ-ын санхүүгийн үйл ажилагаанд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дотоод аудитын алба нь байгууллагын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 24,875.1 сая төгрөгийн төсөв баталсан. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 24,828.5 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилтийг 46,6 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд ОӨУБЕГ нь улсын төсөвт төвлөрүүлэх улсын тэмдэгтийн хураамж, торгуулийн орлого, үйлчилгээний хураамжийн орлого 18,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 18,964.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 105.4 хувиар буюу 964.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Урсгал үйл ажиллагааны батлагдсан төсөв нийт дүнгээр 0.2 хувиар буюу 46.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн ба зардлын ангилалаар авч үзвэл: Цалин, НДШийн зардал 0.1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.8 хувь, Хангамж, бараа материалын зардал 0.2 хувь, эд хогшил урсгал засварын зардал 0.1 хувь, томилолтын зардал 0.2 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 0.02 хувь, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1.3 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

2.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийн байршуулалт 90.9 хувьтай байна. Байгууллагын цахим хуудас www.burtgel.gov.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон.

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргээр 23 нэгжийн хувьд нийт 3,243 мэдээлэл байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 2,948, хугацаа хоцроосон мэдээлэл 123, шаардлага хангаагүй мэдээлэл 171 байна.

Мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгууллагуудыг дурьдвал: Сэлэнгэ, Булган, Архангай, ОӨУБЕГ, Увс, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь аймгуудийн ОӨУБГ-ууд мэдээллээ хугацаа хоцроосон байна. Эдгээр байгууллагууд 5.0 саяаас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг байршуулаагүй, батлагдсан төсвийг буруу оруулсан, төсвийн гүйцэтгэлийн тайлбарыг дутуу оруулсан зэрэг зөрчил гаргасан байна.

2.8 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТООЦСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

2.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар

а. 2017 оны Төрийн сангийн харилцах данс дахь өмнөх оны үлдэгдэл 34.7 сая төгрөгийг дээд шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр жил дамжуулан зарцуулахгүй" гэснийг тус тус зөрчсөн байна.

б. Мөнгөн гүйлгээний тайлан дахь үйл ажиллагааны орлогыг мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 43,5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй

Шийдвэрлэсэн нь: Харилцах дансны татан төвлөрүүлээгүй үлдэгдэл 34.7 сая төгрөгийг төлбөрийн актаар улсын төсөвт татан төвлөрүүлэх, дутуу илэрхийлэгдсэн 43.5 сая төгрөгийн орлогыг дахин сайн нягталж, холбогдох арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

2.9.2 Авлагын талаар

а. Өмнөх онуудаас дамжиж ирсэн хувь хүнтэй холбоотой 32.9 сая, байгууллагатай холбоотой 20.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

б. Зарим аймгийн ОӨУБГ 2017 оны төсөвт зардлын хэмнэлтээс 4.5 сая төгрөгийн НДШ, Татварын зардлыг урьдчилан шилжүүлж, авлага нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Дархан аймгийн ОӨУБГ 2.4 сая, Дорноговь аймгийн ОӨУБГ 1.9 сая төгрөгөөр тус тус авлага нэмэгдүүлжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг жилд 2 удаа тооцоо нийлж баталгаажуулж байх, төсвийн хэмнэлтээс зарим зардлыг санхүүжүүлэхээр урьдчилан шилжүүлж авлага нэмэгдүүлэхгүй байх, олон жил болсон авлага, өглөг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай аудитын зөвлөмж өгөх.



2.9.3 Зардлын талаар

а. ОӨУБЕГ нь цалингийн сангаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 19.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 8.5 сая, хандив тусламжид 5.8 сая, нийт 34.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

б. ОӨУБЕГ-ын аппаратын цалингийн сангаас нийслэлийн болон зарим аймгийн ОӨУБГ-ын НДШ, татварын өглөг 61.7 сая, ашиглалтын зардлын өглөг 10.7 сая төгрөгийг тус тус хааж, шууд харилцагч байгууллагын дансруу шилжүүлж, аппаратын тайлант оны зардлаар тооцсон боловч тус байгууллагуудын орлого үр дүнгийн тайланд тусгуулан зардлыг давхардуулан бүртгэж, тайлагнасан,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн сангаас ОБЕГ-т хандивласан 5.8 сая төгрөгийг төлбөрийн актаар улсын төсөвт татан төвлөрүүлэх, салбар байгууллагуудын өглөгийг барагдуулахдаа төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан, салбар байгууллагуудын дансдаар дамжуулан санхүүжилт олгон үнэн зөв бүртгэж тайлагнаж байх зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. ОӨБЕГ-ын улсын төсөвт төвлөрүүлэх улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамж, торгуулийн орлого болон үнэт цаас /паспорт, иргэний цахим үнэмлэх, зээлийн гэрээний барьцаанаас авах үйлчилгээний шимтгэл, бусад үнэт цаас гэх мэт/-ны орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд бүртгэлээр тавих хяналт сул, үнэт цаасны болон үйлчилгээний орлогын тооцоог сар бүр бодож, үр дүнг тооцож ажилладаггүй, зээлийн барьцааны үйлчилгээний хураамжийн тодорхой бус байгаа нь хөрөнгө, орлого дутагдах, бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.

2. ОӨУБЕГ-ын ҮАГ-т ирүүлсэн хүсэлтийн дагуу тус байгууллагын дарга Р.Содхүү тэргүүтэй албан хаагчид АНУ-д албан ажлаар ажиллах үеийн томилолтын зардлыг ямар эх үүсвэрээс гаргаж зарцуулсан талаар санхүүгийн тайлангийн аудитын явцад тусгайлан шалгасан болно.

- Аудитаар АНУ-д ажиллах хугацааны байр хоол, хотын доторхи унааны зардлыг хамтран ажилласан байгууллага хариуцсан ба АНУ-д очих, ирэх онгоцны тийзийг албан хаагчид хувиараа төлсөн байна.
- Аудитаар ОӨУБЕГ-ын аппаратын ажилтнуудын 1 өдрийн цалинтай тэнцэх хэмжээний хандив болох 5.8 сая төгрөгийг ажилтнуудын цалингаас суутган тооцолгүйгээр байгууллагын цалингийн зардлаас шууд ХЗДХЯ-ны дансруу шилжүүлсэн зөрчлийг илрүүлж, уг хандивын мөнгийг ажилтнуудаас суутган авч байгууллагыг хохиролгүй болгохоор төлбөрийн акт тогтоосон болно.


2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар улсын төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны жилийн өсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 406.6 сая төгрөгийн алдаа зөрчил

САГ-2018/12/СТА-ТТЗ



илэрсэн ба аудитын явцад 89.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 40.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 276.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 10 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 9 зөвлөмжийг бүрэн биелүүлж, авлага барагдуулах тухай 1 зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувийн хэрэгжилттэй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 27,090.2 сая төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 541.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР

ОӨУБЕГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар урьдчилсан байдлаар нийт 130.0 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэсэн болно

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн гүйлгээний тайлан дахь үйл ажиллагааны орлогыг мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 43,5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Хөрөнгө дутагдах,

ҮАГ-ын зөвлөмж

Дутуу илэрхийлэгдсэн орлогыг дахин сайн нягтлан тооцож, зөрүүг тодруулан 2017 оны оны 1 дүгээр улирлын тайланд өмнөх оны үр дүнд залруулга хийх,

Орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах,

Зээлийн барьцааны бүртгэлийн хураамжийн хэмжээг холбогдох журам зааварт тодорхой тусгах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 сарын 01-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

3.2 АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

а. Өмнөх онуудаас дамжиж ирсэн хувь хүнтэй холбоотой 32.9 сая, байгууллагатай холбоотой 20.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

б. Зарим аймгийн ОӨУБГ 2017 оны төсөвт зардлын хэмнэлтээс 4.5 сая төгрөгийн НДШ, Татварын зардлыг урьдчилан шилжүүлж, авлага нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Дархан аймгийн ОӨУБГ 2.4 сая, Дорноговь аймгийн ОӨУБГ 1.9 сая төгрөгөөр тус тус авлага нэмэгдүүлжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, Авлага, өглөг буруу илэрхийлэгдэх, Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Авлагын үлдэгдлийг жилд 2 удаа тооцоо нийлж баталгаажуулж байх,

Төсвийн хэмнэлтээс зарим зардлыг санхүүжүүлэхээр урьдчилан шилжүүлж авлага нэмэгдүүлэхгүй байх,

Олон жил болсон авлага, өглөг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллан авлагыг барадуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 сарын 01-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

3.3 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

а. ОӨУБЕГ нь цалингийн сангаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 19.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 8.5 сая, нийт 28.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

б. ОӨУБЕГ-ын аппаратын цалингийн сангаас нийслэлийн болон зарим аймгийн ОӨУБГ-ын НДШ, татварын өглөг 61.7 сая, ашиглалтын зардлын өглөг 10.7 сая төгрөгийг тус тус хааж, шууд харилцагч байгууллагын дансруу шилжүүлж, аппаратын тайлант оны зардлаар тооцсон боловч тус байгууллагуудын орлого үр дүнгийн тайланд тусгуулан зардлыг давхардуулан бүртгэж, тайлагнасан,

в. Аймаг, нийслэлийн ОӨУБГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн сантай холбоотой нийт 4.3 сая, авлагатай холбоотой 27.8 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалттай холбоотой 2.3 сая, бараа материалын тооллого, бүртгэл хөтлөлттэй холбоотой 15.4, бусад 25.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан, тайлант оны үр дүн буруу илэрхийлэгдэх, Төсвийн үргүй зардал гарах, Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Салбар байгууллагуудын өглөгийг барагдуулахдаа төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан, салбар байгууллагуудын харилцах дансдаар нь дамжуулан санхүүжилт олгож, үнэн зөв бүртгэж тайлагнаж байх,

Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах,

Салбар байгууллагуудын нягтлан бодогчдын чадвахийг сайруулах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 9 сарын 01-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

4 АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017 оны 01-р сарын 01	2017 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		5,667,328.2	6,579,376.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	54,078.9	64,198.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	707,746.4	71,632.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,905,502.8	6,443,545.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		10,313,628.8	7,713,092.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	10,313,628.8	7,713,092.6
39200	Биет хөрөнгө		9,423,839.3	6,599,558.1
39300	Биет бус хөрөнгө	13	889,789.5	1,113,534.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		15,980,957.1	14,292,469.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,715,807.9	35,195.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,715,807.9	35,195.1
41300	Өглөг	17а, 17б	1,698,771.1	5,557.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	17,036.8	29,637.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		14,265,149.1	14,257,274.1
51	Засгийн газрын хувь оролцоо		14,265,149.1	14,257,274.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		11,949,212.1	11,949,212.1
51200	Хуримтлагдсан үр дүн		2,283,659.7	2,275,784.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		32,277.3	32,277.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		15,980,957.1	14,292,469.1

4.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017 оны 01-р сарын 01	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		56,195,407.9	27,090,162.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		128,387.8	0.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж		128,387.8	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	21,557,978.6	1,146,026.5
120	Нийтлэг татварын бус орлого		21,518,891.7	16,049.3
122	Тусламжийн орлого		39,086.8	1,129,977.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		34,509,041.5	25,944,135.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	55,464,399.6	28,669,831.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		55,464,399.6	28,669,831.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,958,663.2	27,799,254.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,931,040.4	12,420,897.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,514,811.5	1,361,477.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		830,772.7	798,167.5
2104	Хангамж, бараа материалын зардал		2,251,551.5	693,802.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		65,534.4	158,061.1
2107	Томилолт, зочны зардал		261,105.9	114,126.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		11,755,631.7	7,914,733.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		6,348,215.1	4,337,990.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,505,736.3	870,576.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		731,008.3	-1,579,669.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-168,182.4	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,544,067.9	7,497.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,981,241.9	-1,587,166.9



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
3	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,554,085.1	0.00	19,554,085.1
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,307,693.9	0.00	-2,307,693.9
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,246,391.1	0.00	17,246,391.2
9	Тайлант үеийн үр дүн	-2,981,241.9	0.00	-2,981,241.9
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,265,149.2	0.00	14,265,149.2
11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,265,149.2	0.00	14,265,149.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,579,291.8	0.00	1,579,291.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,844,441.0	0.00	15,844,441.0
18	Тайлант үеийн үр дүн	-1,587,166.9	0.00	-1,587,166.9
19	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,257,274.1	0.00	14,257,274.1

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017 оны 01-р сарын 01	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		58,095,271.6	52,145,097.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		932,901.3	4,781,622.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		932,901.3	4,781,622.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		932,901.3	4,781,622.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		22,441,476.8	20,138,823.7
120	Нийтлэг татварын бус орлого		22,441,476.8	20,138,823.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		34,720,893.5	27,224,651.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		57,305,414.9	50,672,508.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		57,305,414.9	50,672,508.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,812,209.3	24,634,479.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,676,536.9	12,481,958.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,509,892.2	1,380,998.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		832,307.2	815,060.5
2104	Хангамж, бараа материалын зардал		831,123.9	630,074.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		108,422.6	170,692.9
2107	Томилолт, зочны зардал		270,367.5	126,786.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,163,207.9	6,002,326.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,420,351.2	3,026,581.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		24,493,205.6	26,038,028.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		789,856.7	1,472,589.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		782,909.9	1,443,306.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		782,909.9	1,443,306.5
2200	Дотоод эх үүсвэрээр		782,909.9	1,443,306.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-782,909.9	-1,443,306.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-30.1	11.1
14	Бусад эх үүсвэр		0.00	44.1
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		30.1	33.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		6,916.6	29,294.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		47,162.3	54,078.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		54,079.0	64,198.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,875,052.4	24,828,471.7	46,580.7	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,875,052.4	24,828,471.7	46,580.7	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,187,900.2	24,146,123.3	41,776.9	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,502,707.9	12,470,874.4	31,833.5	99.8
210101	Үндсэн цалин	8,984,250.7	8,966,889.1	17,361.6	99.8
210102	Нэмэгдэл	1,873,207.5	1,864,254.6	8,952.9	99.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	883,060.9	878,390.6	4,670.3	99.5
210105	Гэрээт ажлын хөлс	762,188.8	761,340.1	848.7	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,380,001.0	1,379,798.7	202.3	100.0
210201	Тэтгэврийн даатгал	879,892.5	884,231.9	(4,339.4)	100.5
210202	Тэтгэмжийн даатгал	62,494.4	73,931.7	(11,437.3)	118.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	125,034.6	121,042.6	3,992.0	96.8
210204	Ажилгүйдлийн даатгал	62,524.9	52,279.4	10,245.5	83.6
210205	Эрүүл мэндийн даатгал	250,054.6	248,313.1	1,741.5	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	821,643.6	814,776.5	6,867.1	99.2
210301	Гэрэл, цахилгаан	171,103.5	159,543.7	11,559.8	93.2
210302	Түлш, халаалт	202,630.5	222,192.6	(19,562.1)	109.6
210303	Цэвэр, бохир ус	40,208.7	34,513.0	5,695.7	85.8
210304	Байрны түрээс	407,700.9	398,527.2	9,173.7	97.8
2104	Хангамж, бараа материалын зардал	625,998.8	624,596.4	1,402.4	99.8
210401	Бичиг хэрэг	293,813.0	298,773.9	(4,960.9)	101.7
210402	Тээвэр, шатахуун	75,136.3	81,949.2	(6,812.9)	109.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	174,414.3	160,348.1	14,066.2	91.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,486.5	6,486.5	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,148.7	77,038.8	(890.1)	101.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325,996.5	325,819.9	176.6	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	269,299.7	269,299.7	-	100.0
210604	Урсгал засвар	56,696.8	56,520.2	176.6	99.7
2107	Томилолт, зочны зардал	113,245.5	113,062.8	182.7	99.8
210701	Гадаад албан томилолт	15,000.0	15,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	98,245.5	98,062.8	182.7	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,425,795.3	5,424,801.3	994.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,813,483.9	3,813,173.6	310.3	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	192.0	192.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,057.7	3,000.3	57.4	98.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,187.8	3,794.3	393.5	90.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	125.2	125.2	-	100.0
210807	Газрын төлбөр	2,424.0	2,417.2	6.8	99.7

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	277.2	277.2	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,602,047.5	1,601,821.4	226.1	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,992,511.6	2,992,393.4	118.2	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,896,247.0	2,896,247.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,264.6	96,146.4	118.2	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	687,152.2	682,348.4	4,803.8	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	687,152.2	682,348.4	4,803.8	99.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	309,452.2	309,452.2	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	377,700.0	372,896.2	4,803.8	98.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,875,052.4	24,799,497.5	75,554.9	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,875,052.4	24,799,497.5	75,554.9	99.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	24,875,052.4	24,799,497.5	75,554.9	99.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	54,078.2	(54,078.2)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	64,198.7	(64,198.7)	0.0

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	2017 он	Аудитын нэр	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код	САГ-2018/12/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Төрийн сангийн харилцах данс дахь өмнөх оны үлдэгдэл 34.7 сая төгрөгийг дээд шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлээгүй байна.	34.7	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
2	Мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 83.0 сая төгрөгөөр бууруулан тайлагнасан байна.	83.0	Аудитын явцад залруулсан	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
3	Мөнгөн гүйлгээний тайлан дахь үйл ажиллагааны орлогыг мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 43,5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	43.5	Менежментийн захидлаар зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
4	ОӨУБЕГ-ын аппаратын цалингийн сангаас нийслэлийн болон зарим аймгийн ОӨУБГ-ын НДШ, татварын өглөг 61.7 сая, ашиглалтын зардлын өглөг 10.7 сая төгрөгийг тус тус хааж, шууд харилцагч байгууллагын дансруу шилжүүлж, аппаратын тайлант оны зардлаар тооцсон боловч тус байгууллагуудын орлого үр дүнгийн тайланд тусгуулан зардлыг давхардуулан бүртгэж, тайлагнасан.	72.4	Менежментийн захидлаар зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 6.5 сая төгрөгөөр Бараа материал, хөрөнгийн тодруулга тайлангаас зөрүүтэй илэрхийлсэн байна.	6.5	Аудитын явцад залруулсан	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
6	Цалингийн сангаас ОБЕГ-г хандивласан 5.8 сая төгрөгийг төлбөрийн актаар улсын төсөвт татан төвлөрүүлэх.	5.8	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Р.Содхүү Ч.Хүрэлбаатар
Нийт дүн		245.9			

